

**Арбитрын ажиллагаанд зүй ёсны процессын
параной үүсэхээс урьдчилан сэргийлэх нь**

**Preventing Due Process Paranola in
Arbitration Proceeding**

Эрдэнэбаатарын Эрхбилгүүн

Хууль зүйн ухааны магистр (LL.M.)

Улаанбаатар хот, Монгол Улс.

erkhee365@gmail.com



[Товч утга]

Шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх ажиллагааны нэг төрөл болох арбитрын ажиллагаа нь хурдан, шуурхай байх шаардлагатай боловч зүй ёсны процессын дагуу явагдах шаардлагатай юм. Зүй ёсны процесс нь талуудад тэгш боломж олгох, өөрсдийн байр сууриа бүрэн илэрхийлэх боломжоор хангах зорилготой. Эдгээр нь хангалттай олгогдоогүй нөхцөлд шүүхээс арбитрын шийдвэр хүчин төгөлдөр бус гэж үздэг. Олон улсад арбитрч нар тус үндэслэлээр өөрийн шийдвэрлэсэн арбитрын шийдвэр нь хүчин төгөлдөр бус болохоос эмээн арбитрын ажиллагаа хэт удаашрах асуудал тулгарч байна. Үүнийг олон улсад зүй ёсны процессын параной (Due process paranoia) гэж нэрлэдэг. Манай улсад энэ талаар хараахан судлагдаагүй байгаа учир эрдэм шинжилгээний өгүүлэл бичих нь ач холбогдолтой юм. Энэхүү бэсрэг өгүүллийн хүрээнд арбитр болон шүүхийн ялгаатай тал, арбитрын ажиллагаа дахь зүй ёсны процессын онолын ойлголт, олон улсын болон дотоодын эрх зүйн хэм хэмжээнд зүй ёсны процесс хэрхэн тусгагдсан эсэх, зүй ёсны процессын параной болон үүний талаар авч үзсэн Сингапур болон Япон улсын шүүхийн шийдвэрүүдийг судалсны үндсэн дээр тодорхой санал дэвшүүлсэн болно.

[Түлхүүр үг]

Шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх арга, талуудад тэгш хандах, бүрэн боломж, зүй ёсны процесс, арбитрын шийдвэр.

I. Оршил

Сүүлийн үед олон улсын арилжааны арбитрын эрх зүйд зүй ёсны процессын параной (Due process paranoia) гэх ойлголт анхаарлын төвд байна. Зүй ёсны процессын (Due process) дагуу арбитрын ажиллагаа явагдаагүй гэсэн үндэслэлээр шүүх арбитрын шийдвэрийг хүчингүй болгохоос арбитрч эмээж, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хугацаа хэтрүүлсэн тайлбар болон нотлох баримтыг хүлээн авах, арбитрын хуралдаан үндэслэлгүй хойшлох асуудал түгээмэл үүсэж байна. Энэ нь арбитрын ажиллагааны үр бүтээмжтэй байдалд сөргөөр нөлөөлж байгаа гол асуудал гэж үзжээ.¹ Өөрөөр хэлбэл арбитрын ажиллагаа удаашрснаар түүний үндсэн шинж болох хурдан шуурхай байдал алдагдах, мөн арбитрын зардал нэмэгдэх зэрэг асуудал үүсгэх юм.

Зүй ёсны процесс нь бүхий л процессын ажиллагаанд баримталдаг гол зарчим боловч арбитрыг удаашруулах шалтгаан болж байгаа нь арбитрын ажиллагаа дахь зүй ёсны процессыг зөв зохистой талаас нь ойлгож хэрэгжүүлэх асуудал үүсэж байна. Ингэснээр зүй ёсны процессын паранойг үүсэхээс урьдчилан сэргийлэх боломжтой болно.

Уг асуудлын шийдлийг олохын тулд энэхүү өгүүлэлээр (1) арбитр болон шүүхийн ялгаа, (2) арбитрын ажиллагаа дахь зүй ёсны процессын онолын ойлголт, олон улс болон дотоодын хэм хэмжээнд хэрхэн тусгагдсан эсэх, (3) зүй ёсны процессын параной гэж юу болох, талууд тайлбар гаргах бүрэн боломжийг хангах талаар Сингапур болон Япон улсын шүүхийн шийдвэрт хэрхэн тайлбарласан болохыг судалсны үндсэн дээр дүгнэлт хэсэгт дээрх асуудлыг шийдэх тодорхой санал дэвшүүлэх зорилготой.

II. Арбитр болон шүүхийн ялгаа

Нийгэмд эрх зүйн этгээдүүдийн хооронд үүссэн маргааныг шүүхээс шийдвэрлэхээс гадна шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх аргыг (Alternative Dispute Resolution) ашиглан шийдвэрлэх боломжтой байдаг. Шүүхийн бус журмаар маргаан хянан шийдвэрлэх арга нь олон төрөлтэй. Энэ олон төрлийг арбитр болон

¹ Queen Mary University of London, White & Case, “2018 International Arbitration Survey: The Evolution of International Arbitration” pp. 8, 27 <https://www.lexology.com/library/detail.aspx?g=09595ab0-aba6-4e22-8d12-b1b2dc378710> (Сүүлд үзсэн: 2025.03.15)

Queen Mary University of London, White & Case, “2021 International Arbitration Survey: The Evolution of International Arbitration” pp. 12 https://www.qmul.ac.uk/arbitration/media/arbitration/docs/LON0320037-QMUL-International-Arbitration-Survey-2021_19_WEB.pdf (Сүүлд үзсэн: 2025.03.15)

эвлэрэл гэсэн хоёр үндсэн хэлбэрт хувааж болно.² Эдгээр нь адилхан шүүхийн бус журмаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаардаг боловч ялгаатай талуудтай. Тухайлбал, эвлэрүүлэн зуучлал нь маргалдагч талуудыг тохиролцоонд хүргэхийг зорьдог, харин арбитр нь маргалдагч талуудын тайлбар болон талуудын гаргасан нотлох баримтуудад үндэслэн заавал биелэгдэх шинжтэй шийдвэр (arbitral award) гаргадаг.

Арбитрын шийдвэр заавал биелэгдэх шинжээрээ шүүхтэй төстэй боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ялгаатай онцлогийг тус бүр агуулдаг. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх эрх бүхий шүүх бүрэлдэхүүн дотоодын хууль тогтоомжоор тухайн хэрэг маргааныг шийдвэрлэхэд хэрэглэхээр зохицуулсан зохицуулалтуудыг үндэслэн маргааныг хянан шийдвэрлэх хэлбэрээр явагддаг. Харин арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа талуудаас томилсон эсвэл арбитрын байгууллага болон шүүхээс талуудын хүсэлтэд үндэслэн томилсон хараат бус, бие даасан арбитрын бүрэлдэхүүн маргааныг талуудын хэрэглэхээр тохиролцсон хууль тогтоомжид үндэслэн хянан шийдвэрлэдэг.³

Үүнээс гадна нэхэмжлэгч нь хариуцагчтай урьдчилан тохиролцохгүйгээр шүүхэд нэхэмжлэл, гомдол, хүсэлт гаргах эрхтэй, шүүх дэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь ихэвчлэн тухайн улсын хэлээр явагддаг (хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын аль нэг тухайн улсын хэлийг ойлгохгүй, бусад шалтгаанаар харилцаж чадахгүй тохиолдол хамаарахгүй), хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа 3 шатны шүүх дамжин үргэлжлэх боломжтой, хуульд зааснаас бусад тохиолдолд шүүх хурал нээлттэй явагдана зэрэг онцлогтой байдаг. Харин арбитрын хувьд арбитрын хэлэлцээрийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүсдэг, арбитрын хуралдаан хаалттай явагддаг, талууд арбитрын ажиллагааны журмыг тогтоодог.

Дээрхийг нэгтгэн дүгнэвэл шүүх дэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь дотоодын хууль тогтоомжид заасан журмаар явагддаг, харин арбитрын ажиллагаа нь талуудын сонгосон хэлбэрээр явагдах боломжтой байдгаараа онцлогтой байна.

III. Арбитрын ажиллагаа дахь зүй ёсны процесс

3.1. Зүй ёсны процессын онолын ойлголт

Зүй ёсны процесс хэмээх ойлголтыг түүхэн талаас авч үзвэл

² Д. Тунгалаг, С.Болормаа, Эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэх ажиллагаа, 2015, 45 дахь тал.

³ Мөнхнаран, Олон улсын ба үндэсний арбитрын эрх зүй, 2024, 13 дахь тал.

Магна Хартаас эхлэлтэй бөгөөд Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн 5 дахь нэмэлт өөрчлөлтөд зүй ёсны процессын тухай заасан байдаг. Зүй ёсны процессыг процессын эрх гэж ойлгох нь зүйтэй бөгөөд бүхий л процесс ажиллагаанд баримтлах шаардлагатай. Энэхүү ойлголт нь олон янзын агуулгаар тайлбарлагддаг. Гэхдээ хамгийн суурь ойлголт нь зүй ёсны процессгүйгээр хэний ч эрхэнд халдахгүй гэх утгыг илэрхийлдэг.⁴

Арбитрын ажиллагаа дахь зүй ёсны процессын талаар авч үзэхээс өмнө яагаад арбитрын ажиллагаа зүй ёсны процессын дагуу явагдах шаардлагатай вэ? хэмээх асуултад хариулах хэрэгтэй. Арбитрын ажиллагаа нь талуудын урьдчилан тохиролцсон хэлэлцээрийн үндсэн дээр үүсдэг буюу арбитрын хурлын бүрэн эрх нь арбитрын хэлэлцээрээс үүдэлтэй, харин төрийн бүрэн эрхэд хамааралгүй.⁵ Зүй ёсны **процессын** тухай ойлголт нь анхнаасаа төрийн бүрэн эрхээс хамгаалах, хувь хүмүүсийн шударга болон зүй ёсны хэрэг хянан шийдвэрлэх журмыг баталгаажуулсан бөгөөд үндсэн хуулиар хамгаалагдсан эрх гэж үздэг байсан.⁶ Арбитрын ажиллагаа нь талуудын урьдчилан тохиролцсон хэлэлцээрийн үндсэн дээр үүсдэг буюу арбитрын хурлын бүрэн эрх нь арбитрын хэлэлцээрээс үүдэлтэй, харин төрийн бүрэн эрхэд хамааралгүй учраас арбитрын ажиллагаа нь зүй ёсны процессын дагуу явагдах шаардлагагүй гэж үздэг байсан.⁷ Гэхдээ арбитрыг эрх зүйн тогтолцооны нэг хэсэг болохыг хүлээн зөвшөөрч, шүүхийг орлох маргаан хянан шийдвэрлэх арга, шүүхэд хандах эрхийг хязгаарлаж, мөн арбитрын шийдвэр нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэртэй нэгэн адил эрх зүйн үр дагавартай тул арбитрын ажиллагаанд оролцож буй талуудын процессын эрхийн баталгааг хангахын тулд арбитрын ажиллагаа зүй ёсны процессын дагуу явагдах шаардлагатай гэж үзэх болсон.⁸

Арбитр ажиллагаа дахь зүй ёсны процесс нь Арбитрын ажиллагааны Олон улсын эрх зүйн төвийн захирал, арбитрч Люси Рийд (Lucy Reed) олон улсын арбитр дахь зүй ёсны процессыг (1) талуудад арбитрын ажиллагааны талаар мэдэгдэх, (2) талууд өөрийн байр сууриа илэрхийлэх, хариу тайлбар гаргах боломжтой байх, (3) талууд төвийг сахисан арбитраар маргаанаа шийдвэрлүүлэх эрхтэй

⁴ Aline Beltrame de Moura & Gustavo Becker, The Normative Roots of the “Due Process Paranoia” in International Commercial Arbitration and Its Impacts on Procedural Efficiency, 23 (2019), 173.

⁵ Miyuki Watanabe “Due Process in Arbitration - How to Mitigate Due Process Paranoia?” Japan Commercial Arbitration Journal 5 (2024), 56.

⁶ Miyuki Watanabe “Due Process in Arbitration - How to Mitigate Due Process Paranoia?” Japan Commercial Arbitration Journal 5 (2024), 56.

⁷ Ibid.

⁸ Ibid.

байх, (4) талуудын тэгш эрхийг хангах гэж тодорхойлжээ.⁹ Гэхдээ хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан зүй ёсны процессыг хангах асуудал ялгаатай байх учраас үүнд хэлбэрийн төдий тодорхойлолт өгөх нь зохимжгүй гэж үздэг.¹⁰

Арбитрын шийдвэрийг гүйцэтгэх боломжтой байхын тулд процессын минимум стандартуудыг хангасан байх шаардлагатай бөгөөд эдгээрийг зүй ёсны процессын урьдчилсан нөхцөлүүд гэж үздэг.¹¹ Үүнд, процедурын шударга байдал (Procedural fairness), өөрийн байр сууриа илэрхийлэх боломж (Opportunity to be heard), талуудад тэгш хандах (Equal treatment), шүүхэд хандах эрх (Access to justice) багтана.¹²

3.2. Зүй ёсны процессыг тусгасан олон улсын эрх зүйн хэм хэмжээ

Зүй ёсны процессын талаар олон улсын эрх зүйн хэм хэмжээнд дараах байдлаар тусгагдсан. Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх конвенцын 5 дугаар зүйлийн 5.1.б-д¹³ “Арбитрын шийдвэр сөргөөр нөлөөлөх талд арбитрчийг томилох буюу хэргийг арбитраар хянан шийдвэрлэх талаар зохих ёсоор мэдэгдээгүй, эсхүл бусад шалтгаанаар тайлбараа гаргаж өгч чадаагүй”, ЮНСИТРАЛ-ын загвар хуулийн 18 дугаар зүйлд¹⁴ “Талууд тэгш эрхтэй оролцох ба талууд өөрийн байр суурийг илэрхийлэх боломжоор бүрэн хангагдана”, ЮНСИТРАЛ-ын арбитрын дүрмийн 17 дугаар зүйлд¹⁵ “Арбитрын хуралд талууд тэгш эрхтэй оролцож, арбитрын ажиллагааны зохих үе шатанд талууд хэргийн талаар тайлбар гаргах, зохих боломжоор хангагдсан тохиолдолд арбитр зөв зохистой хэлбэрээр явагдах болно. Арбитрын хуралдаанд арбитрч аливаа шийдвэр гаргахдаа арбитрын ажиллагаа шаардлагагүй удааширах болон зардлаас зайлсхийж, талуудын маргааныг шийдвэрлэхийн тулд шударга, үр дүнтэй ажиллагаа явуулах шаардлагатай” гэж тус бүр заажээ.

⁹ Өмнөх эшлэл(б) 174

¹⁰ 猪股孝史ほか「仲裁におけるdue process」仲裁とADR9号[渡部美由紀発言](2024).

¹¹ Aline Beltrame de Moura & Gustavo Becker, The Normative Roots of the “Due Process Paranoia” in International Commercial Arbitration and Its Impacts on Procedural Efficiency, 23 VJ 174 (2019).

¹² Ibid.

¹³ Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх конвенц (1958) https://www.newyorkconvention.org/media/uploads/pdf/1/2/12_english-text-of-the-new-york-convention.pdf

¹⁴ ЮНСИТРАЛ-ын Олон Улсын Арилжааны Арбитрын тухай загвар хууль (1985), https://uncitral.un.org/sites/uncitral.un.org/files/media-documents/uncitral/en/06-54671_ebook.pdf

¹⁵ ЮНСИТРАЛ-ын дүрэм (1976), https://uncitral.un.org/sites/uncitral.un.org/files/media-documents/uncitral/en/21-07996_expedited-arbitration-e-ebook.pdf

3.3. Зүй ёсны процессыг тусгасан дотоодын эрх зүйн хэм хэмжээ

Монгол Улсын хувьд энэ зарчмын талаар Арбитрын тухай хуулийн¹⁶ 30 дугаар зүйлд *“Арбитрын ажиллагаанд талууд тэгш эрхтэй оролцох ба талууд өөрийн байр суурийг илэрхийлэх боломжоор бүрэн хангагдана”* гэж заасан. Энэхүү зүйлийг арбитрын ажиллагааны талууд тэгш эрхтэй, мэтгэлцэх боломжоор бүрэн хангагдаж, тэгш эрхийн болон мэтгэлцэх зарчмын дагуу талууд тэгш эрхтэй байж өөрийн шаардлага, тайлбар, байр сууриа илэрхийлэх боломжоор бүрэн хангагдсан байна гэж тайлбарлажээ¹⁷. Түүнчлэн Монголын Олон Улсын Арбитрын Хэрэг хянан шийдвэрлэх Дүрмийн 13.1 дэх хэсэгт *“Арбитрын бүрэлдэхүүн нь арбитрын ажиллагааг Талуудын эрх тэгш байдал болон өөрсдийн байр суурийг илэрхийлэх боломжоор хангасан, шуурхай, үр дүнтэй, Талуудын саналыг харгалзан тохиромжтой гэж үзсэн хэлбэрээр явуулна”*, тус дүрмийн 18.1 дэх хэсэгт *“Талууд арбитрын ажиллагаанд тэгш эрхтэй оролцох бөгөөд өөрсдийн байр суурийг илэрхийлэх, мэтгэлцэх боломжоор бүрэн хангагдана”* гэж тус бүр заасан бөгөөд зүй ёсны процессыг байнгын арбитрын дүрмээр мөн баталгаажуулсан байна.

Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл, журмыг заасан байдаг. Шүүх санаачилгаар арбитрын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл бүрдсэн эсэх талаар авч хэлэлцэхгүй бөгөөд шийдвэрийг хүчингүй болгуулах тухай талуудын аль нэг тал нь өргөдөл гаргадаг. Энэ нь диспозитив зарчим үйлчилж байгаа илрэл юм. Шүүхийн зүгээс арбитрын шийдвэрийг хүчингүй болгож болох хоёр хэлбэр байдаг бөгөөд нэгдүгээр хэлбэр буюу өргөдөл гаргагч нотлох тохиолдлууд, хоёрдугаар хэлбэр буюу шүүх өөрөө тогтоосон нөхцөлд тохиолдлууд байдаг¹⁸.

Нэгдүгээр хэлбэр буюу өргөдөл гаргагч нотлох тохиолдлуудыг Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.1-т заасан байдаг. Үүнд:

- Арбитрын хэлэлцээрийн аль нэг тал эрх зүйн чадамжгүй, эсхүл арбитрын хэлэлцээр нь талуудын тохиролцон сонгосон улсын хуульд зааснаар, эсхүл тийнхүү тохиролцон сонгоогүй бол Монгол Улсын хуульд зааснаар хүчин төгөлдөр бус;

- Өргөдөл гаргагч талд арбитрч томилох, арбитрын ажиллагааны тухай зохих ёсоор мэдэгдээгүйн улмаас арбитрын ажиллагаанд зохих ёсоор оролцох боломжгүй байсан;

¹⁶ Арбитрын тухай хууль, 2017, <https://legalinfo.mn/mn/detail/12456>

¹⁷ Д.Дүгэржав, Арбитрын тухай хуулийн товч тайлбар, 2017, 81 дэх тал.

¹⁸ Өмнөх эшлэл 5) 99-100 дахь тал.

- Арбитрын бүрэлдэхүүн нэхэмжлэлийн шаардлагад тусгаагүй, хамааралгүй маргааны талаар үндсэн шийдвэр гаргасан. Хэрэв нэхэмжлэлийн шаардлагад тусгаагүй, хамааралгүй асуудлаар гаргасан арбитрын үндсэн шийдвэрийг нэхэмжлэлийн шаардлагад тусгасан асуудлаар гаргасан шийдвэрээс салгах боломжтой бол холбогдох хэсгийг хүчингүй болгоно;

- Талуудын тохиролцоо нь энэ хуулийн заавал дагаж мөрдөх заалтыг зөрчсөнөөс бусад тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн, арбитрын ажиллагаа талуудын тохиролцоонд нийцээгүй, эсхүл тийнхүү тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн, арбитрын ажиллагаа нь энэ хуульд нийцээгүй.

Дээрх нөхцөлүүдээс 47.2.1.6 дахь хэсэгт *“Өргөдөл гаргагч талд арбитрч томилох, арбитрын ажиллагааны тухай зохих ёсоор мэдэгдээгүйн улмаас арбитрын ажиллагаанд зохих ёсоор оролцох боломжгүй байсан”* гэдэг заалт нь зүй ёсны процессыг зөрчсөн тохиолдолд шууд хамаарна. Энэ зохицуулалт нь ЮНСИТРАЛ-ын загвар хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.а.(II)-с рецепц хийсэн зохицуулалт юм. Үүнээс гадна Арбитрын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.1.6 дахь хэсэгт *“Арбитрын үндсэн шийдвэрээр үүрэг хүлээсэн талд арбитрч томилох, арбитрын ажиллагааны тухай зохих ёсоор мэдэгдээгүй, эсхүл арбитрын ажиллагаанд зохих ёсоор оролцож тайлбар өгөх боломжгүй байсан”* гэж заасан нь дээрхтэй адил үндэслэлээр арбитрын шийдвэрийг гүйцэтгэхээс татгалзах байдлаар хуульчлагджээ.

IV. Зүй ёсны процессын параной

2015 оны олон улсын арбитрын судалгаанд анх удаагаа “Зүй ёсны процессын параной” гэх ойлголтыг дурдсан байдаг. Үүнийг арбитрын зүгээс талууд өөрийн байр сууриа илэрхийлэх боломжоор бүрэн хангагдаагүй гэсэн үндэслэлээр арбитрын шийдвэрийг хүчингүй болгох гомдол гаргахаас эмээж арбитрын ажиллагаанд үр дүнтэй түргэн шуурхай арга хэмжээ авахгүй удаашрах явдал гэжээ.¹⁹

Талуудад өөрийн байр сууриа илэрхийлэх бүрэн боломж олгоно гэдэг нь хэргийн талаар зөв шийдвэр гаргахын тулд шаардлагатай мэдээллийг талуудаар гаргуулах гэсэн агуулгатай.²⁰ Хэргийг шийдвэрлэхэд хангалттай тайлбар болон нотлох баримт бүрдсэн

¹⁹ Queen Mary University of London, White & Case, “2015 International Arbitration Survey: The Evolution of International Arbitration” pp. 2 <https://shop.americanbar.org/PersonifyImages/ProductFiles/262739281/4-And%20Justice%20for%20All.pdf> (Сүүлд үзсэн: 2025.04.16)

²⁰ Miyuki Watanabe “Due Process in Arbitration - How to Mitigate Due Process Paranoia?” Japan Commercial Arbitration Journal 5 (2024), 59.

тохиолдолд нэмэлт тайлбар болон нотлох баримт гаргуулах хүсэлтийг хүлээн авахаас татгалзах нь зүйтэй.²¹ Түүнчлэн, арбитрч болон талууд маргааны зүйл, хэрхэн арбитрын ажиллагаа явагдах талаар нэгдсэн ойлголттой болох чухал.²²

2020 оны Сингапурын шүүхийн шийдвэрт ЮНСИТРАЛ-ын загвар хуулийн 18 дугаар зүйлд заасан хэргийн талаар тайлбар гаргах “бүрэн боломж” гэдэг нь хязгаарлалтгүй олгосон боломж биш бөгөөд загвар хуулийн төсөл боловсруулагчид арбитрын ажиллагааг удаашруулахгүй тулд арбитрын түргэн шуурхай үр дүнтэй байх өнцгийг харгалзан үзэх нь чухал гэжээ²³. Өөрөөр хэлбэл, өөрсдийн байр сууриа гаргах бүрэн боломж нь арбитрын ажиллагааг удаашруулах үндэслэл болох ёсгүй. Түүнчлэн, 2019 оны Япон Улсын шүүхийн шийдвэрт²⁴, Японы Арбитрын тухай хуулийн²⁵ 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Арбитрын ажиллагаанд талууд тэгш эрхтэй оролцох ёстой”, мөн тус зүйлийн 2 дахь хэсэгт “Арбитрын ажиллагаанд талууд хэргийн талаар өөрсдийн байр сууриа илэрхийлэх бүрэн боломжоор хангагдах ёстой” гэж тус бүр заасныг дотоодын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн тайлбартай холбон авч үзэх бус, бусад улсуудын Арбитрын хуулийн тайлбар, олон улсын нийтлэг тайлбарт үндэслэх ёстой. Мөн, арбитрч нь шүүхийн процессоос ялгаатай нь арбитрын ажиллагаа түргэн шуурхай, уян хатан, мэргэжлийн байх шинжийг сайтар ойлгох нь чухал. Тиймээс арбитрын ажиллагаанд удаашрал, өндөр зардал үүсгэхгүй байх шаардлагатай гэжээ. Эдгээр 2 шийдвэрээс үзэхэд ЮНСИТРАЛ-ын загвар хуулийг боловсруулах үеийн төсөл боловсруулагч нар “бүрэн боломж” гэдгийг хязгааргүй эдлэх эрх биш ба арбитрын ажиллагааны онцлогт тулгуурлан явагдсанаар хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрахгүй. Түүнчлэн арбитрын ажиллагааны хурдан шуурхай байх шинжийг харгалзан хугацаа хэтрүүлэн гаргасан тайлбар, нотлох баримтыг хүлээн авахаас аль болох татгалзах нь зүйтэй.

V. Дүгнэлт

Арбитрын ажиллагаа нь шүүхээс ялгаатай нь арбитрын хэлэлцээрийн үр дүнд үүсдэг учир уг ажиллагаанд зүй ёсны процессыг

²¹ Мөн тэнд.

²² Мөн тэнд, 60.

²³ China Machine New Energy Corporation v Jaguar Energy Guatemala LLC and another, [2020] 41-43. file:///C:/Users/User/Downloads/[2020]%20SGCA%2012.pdf (Сүүлд үзсэн: 2025.04.16)

²⁴ 高橋 宏司「日本法から見た「適正手続パラノイア(due process paranoia)」JCAジャーナル66巻8号(2019年)14頁～15頁。

²⁵ Япон Улсын Арбитрын тухай хууль, 2003. <https://laws.e-gov.go.jp/law/415AC0000000138>

баримтлах шаардлагагүй гэж үздэг байсан. Гэхдээ эрх зүйн хөгжлийн явцад талуудын процессын эрхийн баталгааг хангахын тулд арбитрын ажиллагаа зүй ёсны процессын дагуу явагдах шаардлагатай гэж үзэх болсон. Олон улсад арбитрын ажиллагаа дахь зүй ёсны процессын тодорхойлсон нэгдсэн тодорхойлолт байхгүй, хийсвэр ойлголт учраас хэлбэрийн төдий тодорхойлолт өгөх нь зохимжгүй. Гэхдээ өгүүллийн үндсэн хэсэгт дурдсан агуулгын хүрээнд ерөнхийд нь ойлгодог. Арбитрын ажиллагаа нь зүй ёсны процессын дагуу явагдах нь арбитрын шийдвэрийг гүйцэтгэх нөхцөл болдог. Олон улсын болон дотоодын хэм хэмжээнд талуудад тэгш хандах, байр суурийг илэрхийлэх бүрэн боломжоор хангагдах гэж тусгагджээ.

Талууд өөрсдийн байр сууриа илэрхийлэх боломжоор бүрэн хангагдах эрхтэй боловч энэ нь хэтэрсэн тохиолдолд арбитрын ажиллагааны хурдан шуурхай үр дүнтэй байх шинж алдагдана. Олон улсын практикт энэ байдал нэгэнт үүсээд байгаа бөгөөд зарим орны шүүхээс уг асуудлыг авч үзэхдээ ЮНСИТРАЛ-ын загвар хуулийг боловсруулах үеийн төслийн үзэл баримтлалыг авч үзсэнээс гадна арбитрын онцлог буюу хурдан шуурхай байх шинжийг харгалзан “бүрэн боломж”-р хангагдах ёстой гэжээ. Монгол Улсад арбитрын ажиллагаа хурдан шуурхай явагдахаас гадна зүй процессын дагуу явагдахад дараах зүйлсийг харгалзаж үзэх үүднээс санал дэвшүүлж байна.

1. Арбитрын тухай хуулийн 30 дүгээр зүйлд заасан “бүрэн боломж” нь хязгааргүй зүйл биш бөгөөд энэ талаар арбитрын байгууллагын хэрэг хянан шийдвэрлэх дүрэмд “арбитрын ажиллагааны хурдан шуурхай байх шинжийг алдагдуулахгүйгээр өөрийн байр сууриа илэрхийлэх бүрэн боломжоор хангагдана” гэж тусгах;

2. Хууль болон дүрмээр арбитрын ажиллагааны хугацааг заах нь тохиромжгүй. Учир нь тухайн хэргийн онцлогоос хамаарч арбитрын ажиллагаа үргэлжлэх хугацаа харилцан адилгүй. Энэ тохиолдолд арбитрч өөрийн туршлагад тулгуурлан арбитрын ажиллагаа явагдах хугацааг талуудад санал болгох боломжтой. Талууд зөвшөөрсөн тохиолдолд арбитрын ажиллагааны явагдах хугацаанд багтан тайлбар болон нотлох гаргах;

3. Арбитрын ажиллагааны журам нь талуудын хүсэл зоригийн үндсэн дээр тогтдог тул хүндэтгэн үзэх шалтгаантай бол хугацаа хэтрүүлсэн тайлбар болон нотлох баримтыг арбитрч зөвхөн нэг удаа хүлээн авах тухай дүрэмд тусгах.

[Ном зүй]

Д. Тунгалаг, С.Болормаа, *Эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэх ажиллагаа*, 2015.

Д.Дүгэржав, *Арбитрын тухай хуулийн товч тайлбар*, 2017

М.Мөнхнаран, *Олон улсын ба үндэсний арбитрын эрх зүй*, 2024

Aline Beltrame de Moura & Gustavo Becker, The Normative Roots of the “Due Process Paranoia” in International Commercial Arbitration and Its Impacts on Procedural Efficiency, 23 VJ (2019).

Miyuki Watanabe “Due Process in Arbitration - How to Mitigate Due Process Paranoia?” Japan Commercial Arbitration Journal 5 (2024)

高橋 宏司「日本法から見た「適正手続パラノイア (due process paranoia)」 JCAジャーナル66巻8号(2019年)。

猪股孝史ほか「仲裁におけるdue process」仲裁とADR9号 [渡部美由紀発言] (2024)。

Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх конвенц (1958)

ЮНСИТРАЛ-ын дүрэм (1976)

ЮНСИТРАЛ-ын загвар хууль (1985)

Япон Улсын Арбитрын тухай хууль (2003)

Монгол Улсын Арбитрын тухай хууль (2017)

Queen Mary University of London, White & Case, “2015 International Arbitration Survey: The Evolution of International Arbitration” pp. 2

<https://shop.americanbar.org/PersonifyImages/ProductFiles/262739281/4-And%20Justice%20for%20All.pdf>

Queen Mary University of London, White & Case, “2018 International Arbitration Survey: The Evolution of International Arbitration”

<https://www.lexology.com/library/detail.aspx?g=09595ab0-aba6-4e22-8d12-b1b2dc378710>

Queen Mary University of London, White & Case, “2021 International Arbitration Survey: The Evolution of International Arbitration”

https://www.qmul.ac.uk/arbitration/media/arbitration/docs/LON0320037-QMUL-International-Arbitration-Survey-2021_19_WEB.pdf

[Abstract]

Preventing Due Process Paranoia in Arbitration Proceeding

Erdenebaatar Erkhbilguun

Master of Laws (LL.M.)

Ulaanbaatar, Mongolia

Arbitration is a type of alternative dispute resolution process that is not judicial, and while it is required to be fast and efficient, it must also adhere to the principle of due process. Due process aims to provide parties with equal opportunities and ensure they have the ability to fully express their positions. If these rights are not adequately provided, courts may consider an arbitral award as invalid. Internationally, arbitrators are often concerned that an arbitral award may be deemed invalid on the grounds of not adhering to due process, which leads to a delay in arbitration proceedings. This issue is referred to as “Due Process Paranoia”. This issue has not been extensively studied in our country, and this article explores it. This article examines the differences between arbitration and court proceedings, the understanding of due process in arbitration, how it is reflected in both international and domestic legal norms, and analyzes court decisions from Singapore and Japan regarding due process paranoia, based on these, offers specific proposals.

[Keywords]

Alternative dispute resolution, equal treatment of parties, full opportunity, due process, arbitral award.